

ДАРХАН ТАЙЖ ХАСАРЫН НЭРЭМЖИТ ТӨВИЙН БҮСИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ҮЗЭСГЭЛЭН ТЭМЦЭЭНИЙ ТАЙЛАН


2023.04.25

Дархан-Уул аймаг

Монгол Улсын Засгийн газраас 2023-2025 оныг “Монголд зочлох жил” болгон зарласантай холбогдуулан соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх хүрээнд Монголын уугуул үүлдэр Монгол нохойг устаж, ховордохоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, үржүүлэх, эргээн нутагшуулах зорилгоор цэвэр үүлдрийн нохойны стандартыг сурталчлан таниулах, өвлөн уламжлуулах зорилготой "Дархан тайж хасарын нэрэмжит төвийн бүсийн аварга шалгаруулах үзэсгэлэн тэмцээн"-ийг 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр Дархан хотноо анх удаагаа зохион байгууллаа.

Үзэсгэлэн тэмцээнд ОХУ Буриад, Улаанбаатар, Эрдэнэт, Сэлэнгэ, Төв, Өвөрхангай аймгууд болон Дарханаас оролцож 3-6 сартай эр, эм, 1 настай эр, эм, 2 настай эр, эм, 3 болон түүнээс дээш настай эр, эм гэсэн 8 ангилалд нийт 71 ноход өрсөлдөж нийт 150 гаруй үзэгчид хүрэлцэн ирж үзэсгэлэн тэмцээний дүрмийн дагуу ангилал бүрд 1-ээс 5 дугаар байр шаргарууллаа. Мөн нийт 8 ангилалын шилдгүүдээс шүүж "Шилдэг эм нохдын ангилал"-д Б.Батжаргал эзэнтэй "Аньс" дуудлагатай нохой, "Шилдэг эр нохдын ангилал"-д Н.Төгссайхан эзэнтэй "Таягт" дуудлагатай нохой тус тус "ҮЗЭСГЭЛЭНГИЙН АВАРГА"-аар шалгаруулж цом гардуулсан.

Тэмцээнийг Монгол нохой судлаач, СТА Б.Эрдэнэбат шүүж Дархан-Уул аймгийн Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч, “Тайж хасар банхар” НҮТББ-ын тэргүүн А.Нямпүрэвийн санаачилгаар УИХ-ын гишүүн Болдын Жавхлангийн ажлын албаны дэмжлэгээр, Дархан-Уул аймгийн Соёл, урлагийн газар, аймгийн Музей ARTGER медиа групп хамтран зохион байгууллаа. Тус үзэсгэлэн, тэмцээний анос, өргөмжлөл, зохион байгуулагчийн мандат зэргийг эхийг бэлтгэж хэвлэлээ.





ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР